



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 5/24

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Хориг тавих тухай

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоолын “Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Шарын Цогтоог Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй” гэсэн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан үндсэн бүрэн эрхийнхээ дагуу хэсэгчлэн хориг тавьж байна.

Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно” гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болж байх ёстой Үндсэн хуулийн цэцийг байгуулах, түүний гишүүнийг томилж, чөлөөлөх асуудалд Улсын Их Хурал дур зоргын байдлаар хандах, Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдоогүй эрхийг эдлэх боломжгүй гэж үзэж байна.

Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл ...анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно” гэж заасан. Үндсэн хуулийн энэ заалтыг эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг нэр зааж, эгүүлэн татах саналаа Улсын Их Хуралд тавихаас биш Үндсэн хуулийн цэцийн гишүүд хууль зөрчсөн тул санал болгож томилуулсан хүмүүсийнхээ аль нэгийг нь эгүүлэн татая гэх байдлаар санал тавих боломжгүй нь нэн тодорхой юм.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг санал болгох болон томилох бүрэн эрхийг тогтоосон Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг мөн үүний нэгэн адил хэрэгжих ёстой бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь дууссан гишүүдийн аль нэгнийх нь оронд энэ хүнийг томилоорой гэдэг тал зассан, тодорхойгүй саналаар асуудлыг шийдвэрлэх нь хуульт ёсонд нийцэхгүй гэж үзэж байна.

Дамдинсүрэнгийн Солонго, Шарын Цогтоо нарыг Улсын дээд шүүхээс санал болгосны дагуу Монгол Улсын Их Хурал 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 70 дугаар тогтоолоороо Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилжээ. Үндсэн хуулийн

2021000292

цэцийн эдгээр гишүүд нэг өдөр, нэг тогтоолоор томилогдож, бүрэн эрхийн хугацаа нь нэгэн зэрэг дууссан байна.

Гэтэл Улсын дээд шүүх бүрэн эрхийн хугацаа нь дууссан Үндсэн хуулийн цэцийн хоёр гишүүний оронд нэг хүнийг санал болгосон байх бөгөөд ингэхдээ тухайн хүнийг Д.Солонго, Ш.Цогтоо нарын хэнийх нь оронд санал болгосноо бүрэн эрхийнхээ дагуу нэг мөр шийдвэрлэхгүй орхигдуулсан нь Үндсэн хуулийн зөрчилд хөтөлж байна.

Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий Үндсэн хуулийн цэцийг хууль зүйн аливаа зөрчил, маргаангүйгээр байгуулах нь санал болгох болон томилох эрх бүхий байгууллагуудын Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг юм.

Харамсалтай нь өнөөдөр Улсын дээд шүүх нь санал болгох бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүйд хүртлээ, гагцхүү Үндсэн хуульд захирагдаж ажиллах ёстой Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулиа илэрхий зөрчсөн байдлаар маргаан үүсгэх хэмжээнд очтолоо, гаргасан шийдвэрээ албажуулж чадахгүй болтлоо улс төрийн нөлөө дарамтад орж, хараат бус байдлаа алдаж байна.

Энэ бол сайн зүйл биш. Үүнийг би төрийн дээр нам ноёлж, Үндсэн хуульд ёс гажуудан, "засаг төр"-ийн тогтолцоо "нам төр"-ийн тогтолцоонд эргэн шилжиж, дарангуйллын дэглэм алгуурхан боловч тууштай сэргэж байгаагийн нэг тод илрэл гэж үзэж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.7-д "Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах" нь зөвхөн Улсын дээд шүүхийн бүрэн эрх байхаар хуульчилсан.

Энэ хүрээнд манай Тамгын газраас Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хандаж, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон Ж.Эрдэнэбулганыг бүрэн эрхийн хугацаа нь нэгэн адил дууссан Д.Солонго, Ш.Цогтоо нарын хэнийх нь оронд санал болгосон талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны байр суурь, саналыг тодруулан ирүүлэхийг хүсэхэд тус шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр "Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлөх, томилох бүрэн эрх Улсын Их Хуралд хадгалагдаж байна" гэх утга бүхий хариуг ирүүлжээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үзэмжээрээ томилж, чөлөөлөх эрхийг Улсын Их Хуралд холбогдох хууль нь олгоогүй бөгөөд үүнийг Улсын Их Хурлын бүрэн эрхийг тогтоосон Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлээс тодорхой харж болно. Мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг Улсын Их Хурал зөвхөн Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлд заасны дагуу санал болгох бүрэн эрх бүхий байгууллагынх нь саналаар томилж, чөлөөлнө гэдэгтэй маргах аргагүй юм.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн ...25.8-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана” гэж заасан тул Ж.Эрдэнэбулганыг Д.Солонго, Ш.Цогтоо нарын хэнийх нь оронд санал болгосон талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны байр суурь, саналыг тус шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч биш Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан нь гаргаж, илэрхийлэх нь хууль ёсны болно.

Улс орны тусгаар тогтнол, иргэдийн эрх, эрх чөлөөний гол баталгаа болж байдаг Үндсэн хуулийг чандлан сахиулах үндсэн үүрэг бүхий Үндсэн хуулийн цэцийг хууль зүйн зөрчил, маргаангүй байгуулах Улсын Их Хурлын үүрэг болно.

Тиймээс Улсын Их Хурал энэхүү хоригийг хүлээн авч, Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд шууд хамаарч байгаа Үндсэн хуулийн цэцийн гишүүний томилгооны асуудлыг зохих хууль, журмынх нь дагуу шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн бүрэн эрхийн хугацаа нь дууссан Д.Солонго Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр улиран ажиллах хүсэлтээ Улсын дээд шүүхэд илэрхийлсэн боловч нийт шүүгчдийн хуралдаанаар дэмжээгүй байх бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчид хоёр ч удаагийн санал хураалтаар түүнийг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллуулахаас татгалзжээ. Энэ нь Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон Ж.Эрдэнэбулганыг Д.Солонгоны оронд томилох хууль зүйн тодорхой үндэслэл болно гэж үзэж байна.

Мөн Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсгийн “Цэцийн ...гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.” гэсэн маш тодорхой хуулийн заалтыг зөрчиж, Улсын дээд шүүхээс Ш.Цогтоог чөлөөлүүлэх санал гаргаагүй, түүнчлэн Ш.Цогтоог чөлөөлөх асуудлыг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж санал, дүгнэлт гаргаагүй байхад чуулганы нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцэн шийдвэрлэсэн төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд огт нийцэхгүй байна.

Хоригийг зохих хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА